



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Л.ЦЭНГҮҮНЖАВ

“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК-ИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮНИЙ НӨӨЦИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.02.15

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа, Хариуцах албан тушаалтан
Зорилт 1. Хүний нөөцийн стратеги, бодлого, төлөвлөлтийг сайжруулах					
1.1	Компанийн хүний нөөцийн үйл ажиллагаанд баримтлах баримт бичиг, дүрэм журмыг хүний нөөцийн стратеги, бодлого, төлөвлөлтийн хүрээнд шинэчлэн сайжруулж мөрдүүлэх	Хийгдсэн ажлууд	Шинээр батлагдсан, нэмэлт, өөрчлөлт орсон хуулиуд, холбогдох журамд нийцүүлэн компанийн хүний нөөцийн үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмыг шинэчилж, хэрэгжилтийг ханган ажилласан. Тухайлбал, 2023 онд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн компанийн “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”, “Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж баталсан.	Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хүний нөөцийн үйл ажиллагаанд баримтлах баримт бичиг, дүрэм журмыг шинэчлэн сайжруулснаар компанийн хүний нөөцөд тавигдах шаардлагыг оновчтой зөв тодорхойлж, хүний нөөцийг бүрдүүлэх, хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаа тодорхой, тэгш, шударга байх, компанийн засаглал, байгууллагын соёлыг төлөвшиүүлэх, хүний нөөцийн чадамжийг сайжруулах, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангахад зэрэг нөлөө үзүүлнэ.	I-II улирал СЗУХ-ийн дарга, Захиргаа, Хуулийн ахлах мэргэжилтэн
1.2	Компанийн бүтэц, орон тоонд нийцүүлэн хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, албан тушаалын	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, тоо, үр дүн	Компанийн бүтэц, орон тооны хүрээнд нэн түрүүнд шаардлагатай сул орон тооны сонгон шалгаруулалтыг компанийн “Хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу	Компанийн бүтэц, орон тооны дагуу сул ажлын байрны орон тоонд ажилтан сонгон шалгаруулалтыг журмын дагуу нээлттэй явуулж албан тушаалын тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан ажил горилогчийг ажилд авах замаар хүний нөөцийг бүрдүүлсэн байна.	I-IV улирал СЗУХ-ийн дарга, Захиргаа, хүний

	тодорхойлолтын шаардлагын дагуу ажлын байрны сул орон тоо, хүний нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах		зохион байгуулж ажил үүргийн хэвийн байдлыг ханган ажилласан ба 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хүндэт зочны албаны үйлчилгээнд 18, СЗУХ болон НБЗХ-ийн хэлтэст 13, нийт 31 ажилтан байна.		нөөцийн мэргэжилтэн
1.3	Зам, тээврийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 04 дугаартай албан даалгаврын дагуу Салбарын хүний нөөцийн мэдээллийг нэгтгэх ажлын хүрээнд “Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ”-д компанийн хүний нөөцийн дэлгэрэнгүй мэдээллийг бүрэн оруулж мэдээллийн санг шинэчилж байх.	Мэдээллийг шинэчилсэн удаа, тоо дүн	“Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем”-ийг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ”-д нэгдэж салбарын хүний нөөцийн мэдээллийг нэгтгэхэд 2022 оноос эхлэн компанийн хүний нөөцийн мэдээллийг цахим мэдээллийн нэгдсэн санд оруулж эхэлсэн. Хүний нөөцдөд өөрчлөлт орсон тухай бүр мэдээллийг тогтмол шинэчилж байгаа ба 2023.12.31-ний өдрийн байдлаар компани нийт 31 ажилтантай, үүнээс компанийн удирдах 3 албан тушаалтан болон туршилтын хугацаагаар шинээр ажилд орсноос бусад 24 үндсэн ажилтны мэдээлэл https://www.platform.mrtd.gov.mn платформд бүрэн орсон.	“Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ”-д салбарын хүний нөөцийн мэдээллийг нэгтгэх ажлын хүрээнд компанийн хүний нөөцийн мэдээллийг бүрэн оруулж, өөрчлөлт орсон тухай бүрд мэдээллийг үнэн зөв оруулан, мэдээллийн санг бүрдүүлж ажиллана.	I-IV улирал Захиргаа, хүний нөөцийн мэргэжилтэн

Зорилт 2. Хүний нөөцийг чадавхжуулах, мэргэшүүлэх, ажилтны ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх

2.1	Компанийн хүний нөөцийг хөгжүүлэх,		2023 онд компанийн хүний нөөцийн сургалтын арга	Хүний нөөцийн чадавх, ажилтны мэдлэг, боловсрол, ажил мэргэжлийн үр	I-IV улирал
-----	------------------------------------	--	---	---	-------------

	чадавхжуулах, мэргэшүүлэх, ажлын гүйцэтгэл, үр дүн, бүтээмжийг дээшлүүлэх, хариуцлагыг сайжруулахад чиглэсэн сургалт хөгжлийн төлөвлөгөө боловсруулан баталж, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Хэрэгжилтийн хувь, сургалтын үр дүн	хэмжээний төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу ажилтныг сургах, давтан сургах, ажил мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр нийт 7 төрлийн 62 академик цагийн танхимын сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулж, компанийн ажилтнуудыг бүрэн хамруулав.	чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, ажлын гүйцэтгэл, үр дүнг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх, харилцаа хандлагыг сайжруулах, байгууллагын соёлын чиглэлээр тасралтгүй боловсролыг хангахад чиглэсэн сургалтуудыг жил бүр төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажиллана. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан компанийн 2024 оны бизнес төлөвлөгөө, батлагдсан төсвийн хүрээнд жилийн сургалт хөгжлийн үйл ажиллагааг Зам, тээврийн салбарын хүний нөөцийн чиглэлээрх нэгдсэн бодлогод уялдуулан төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллана.	Хэлтэс, албаны дарга, Захиргаа, хүний нөөцийн мэргэжилтэн, Гадаад харилцаа, сургалт хариуцсан мэргэжилтэн
2.2	Ажилтан ажил мэргэжил, албан тушаалын хүрээнд мэргэшлээ ахиулах, мэргэшлийн заавал болон давтан сургалтад хамрагдах, шалгалт өгөх боломж нөхцөлийг хангаж, дэмжлэг үзүүлж ажиллах	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, тоо, үр дүн	Ажилтан ажил мэргэжил, албан тушаалын дагуу мэргэших, мэргэшлийн заавал болон давтан сургалтад хамрагдах, мэргэшлийн шалгалт өгөх зэрэг тохиолдолд цалинтай чөлөө олгох, мөн ажилтан ажил мэргэжлийн шаардлагаар, ажлын байр, албан тушаалын ажил үүрэгт хамаарах сургалтад хамрагдах тохиолдолд компанийс сургалтын төлбөрийн тодорхой хувиар дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг “Хөдөлмөрийн дотоод журам”-д тусгаж өгсөн.	Ажилтан ажил мэргэжил, албан тушаалын дагуу мэргэших, мэргэшлийн заавал болон давтан сургалтад хамрагдах, мэргэшлийн шалгалт өгөх, ажлын байр, албан тушаалын ажил үүрэгт хамаарах сургалтад хамрагдах зэрэг тохиолдолд цалинтай чөлөө олгох, мөнгөн тусламж, дэмжлэг үзүүлэх, компаниас сургалтын төлбөрийг хариуцах хэлбэрээр зохицуулалт хийж ажилтны сурч хөгжих, мэдлэг чадвараа ахиулахыг дэмжиж урамшуулан ажиллана.	I-IV улирал СЗУХ-ийн дарга, Ерөнхий нягтлан бодогч, Захиргаа, хүний нөөцийн мэргэжилтэн
2.3	Ажилтнуудыг ажлын бүтээмж, гүйцэтгэл, түүний үр дүнгээр нь	Хэрэгжилтийн хувь	Ажилтны ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт нь ажилтанд	Мэдлэг, үр чадвар, туршлага сайн, гүйцэтгэл, ажлын үр дүн өндөр ажилтныг тогтворт суурьшилтай ажиллуулах, идэвх	I-IV улирал

	дүгнэж үнэлэх, урамшуулал болон хариуцлагын тогтолцоог сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх		нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал олгох, цалинг нэмэгдүүлэх, албан тушаал ахиулах болон хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох, хариуцлага тооцох үндэслэл болох тухай компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”, ажилтан, ажил олгогч хооронд байгуулсан Хөдөлмөрийн гэрээ болон албан тушаалын тодорхойлолтод тодорхой тусгаж, хөдөлмөрийн сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хэрэгжилтийг ажлын тайлан, үнэлгээ, нэгжийн удирдлагын хяналтын хэлбэрээр дүгнэн ажиллаж байна.	санаачилга, хичээл зүтгэлийг шударгаар үнэлэх нөхцөлийг бүрдүүлж, урамшуулах, эсрэгээр ажлын байрны шаардлага хангахгүй, гүйцэтгэл, бүтээмж, үр дүн муу, сул, идэвх санаачилгагүй ажилтанд хариуцлага тооцох, албан тушаал, цалинг буруулах, шаардлагатай тохиолдолд ажлаас чөлөөлөх сахилга хариуцлагын болон шагнал урамшууллын оновчтой шударга зарчмыг хэрэгжүүлж ажиллана. Ажилтны ажлын байрны шаардлагыг хангаж буй байдал, мэдлэг, үр чадвар, туршилага болон ажил байдлын үнэлгээ, ажлын бүтээмж, гүйцэтгэл, үр дүнг харгалзан ажилтныг урамшуулах, үнэлэх, дэмжих бодлогыг хэрэгжүүлж хөдөлмөр эрхлэлтийн харилцааны холбогдох баримт бичиг, хөдөлмөрийн гэрээнд тусгаж мөрдүүлнэ.	СЗУХ Хэлтэс, албаны дарга, Захиргаа, Хуулийн ахлах мэргэжилтэн
2.4	Ажилтнуудын, ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн ажил, арга хэмжээг жил бүр тогтмол төлөвлөж хэрэгжүүлэх.	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, тоо, үр дүн	Жилийн төлөвлөгөөний дагуу 2023 онд Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц үзлэгт 22 ажилтан, 5 төрлийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд үйлчилгээний 15 ажилтан жилд 2 удаа тус тус хамрагдсан. Эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын танхимын болон цахим сургалтад 28 ажилтан хамрагдсан.	Ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтыг жил бүр тогтмол зохион байгуулна. Ажлын байр, ажилтны эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллыг хангах чиглэлээр үйлчилгээний байр талбайн хяналт, үзлэг шалгалтыг тогтмол хийж, үйлчилгээний ажилтнуудыг холбогдох журам, стандартын дагуу жилд 2 удаа тогтмол эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулна.	I-IV улирал ХАБЭА болон Гадаад харилцаа, сургалт хариуцсан мэргэжилтэн, Захиргаа, хүний нөөцийн мэргэжилтэн
Зорилт 3. Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах					